



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 29 өдөр

Дугаар А/120

Номгон


Г Хөрөнгө зарцуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.11, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3.3, Өвөлжилт, хаваржилтын байдал хүндэрсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Монгол улсын засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоол, “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.1, аймгийн Онцгой комиссын 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн IV хуралдааны хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засаг даргын албан хэрэгцээнд ашигладаг 00-01 БНА улсын дугаартай автомашиныг яаралтай засварлаж хэвийн үйл ажиллагаанд оруулах ажлыг Засаг даргын Тамгын газрын төрийн захиргааны удирдлагын хэлтэс (П.Отгонбаяр)-д үүрэг болгосугай.

2. Дээрх ажилд шаардлагатай 48,000,000 (Дөчин найман сая) төгрөгийн хөрөнгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Д.Энхжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч дарга (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

624017213